



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021-3-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2020 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг:

Ахлах аудитор: П.Мөнхтуяа

Утас: 70342716

Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХАК	Хувийн аудитын компани
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	3
3.Аудитын тайлан.....	13
3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	13
3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	14
3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ	14
3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ.....	14
3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	14
3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ	16
3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	16
3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.....	16
3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	18
3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД.....	18
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

- 1.Төрийн аудитын санал, дүгнэлт**
 - 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**
 - 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
 - 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
 - 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
 - 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**
 - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
 - 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**
-



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.05.15 № 121

Танай _____-ны № _____ т

“БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК-ИЙ
ЗАХИРАЛ Б.ОДХҮҮ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Булган мээж” ОНӨХХК-ий 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Булган мээж” ОНӨХХК-ий 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

006020250

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1124716501.43</u>	<u>7422038293.89</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	590211833.70	137975335.68
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	2533625.26	937551.85
31110	Төгрөг	2533625.26	937551.85
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	587431784.44	136889037.83
3121	Төгрөг	587431784.44	43106249.66
31213	Арилжааны банк дахь харилцах	587431784.44	43106249.66
3122	Гадаад валют	0.00	93782788.17
31223	Арилжааны банк дахь харилцах		93782788.17
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	246424.00	148746.00
33	АВЛАГА	156284018.18	208254629.57
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	64550916.84	97850353.60
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	35578713.86	96979877.21
335	Бусад авлага	56154387.48	13424398.76
3351	Байгууллагаас авах авлага	56154387.48	13424398.76
35	БАРАА МАТЕРИАЛ	334720641.37	7036808328.64
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	68890880.00	6776628377.18
354	Хангамжийн материал	265829761.37	260179951.46
35410	Бичиг хэргийн материал	1027305.09	1272629.09
35420	Аж ахуйн материал	28488711.80	22943689.11
35430	Сэлбэг хэрэгсэл	119595852.19	117098652.53
35440	Түлш, шатах тослох материал	21946952.38	17074891.32
35450	Барилгын засварын материал	18333570.39	19217196.44
35470	Бусад хангамжийн материал	76437369.52	82572892.97
36	НӨӨЦИЙН БАРАА	43500008.18	39000000.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	43500008.18	39000000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6837347692.22</u>	<u>6468787175.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6837347692.22	6468787175.73
391	Газар	510904000.00	539089000.00
392	Биет хөрөнгө	6326243692.22	5920498175.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	1271866221.98	1274151149.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	-263307369.97	-319311797.65
39203	Авто-тээврийн хэрэгсэл	562486750.00	528543000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-354170883.78	-372190815.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7331060520.78	7334613865.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2272506121.71	-2579574210.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88580008.36	75154340.86

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39208	Хуримтлагдсан элэгдэл	-37765433.44	-20887356.37
393	Биет бус хөрөнгө	200000.00	9200000.00
39301	Програм хангамж		9000000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	200000.00	200000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7962064193.65	13890825469.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3584517121.55	11048274861.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	61146802.03	828490560.58
413	Өглөг	60821725.03	822317269.12
4136	Бусад өглөг	60821725.03	822317269.12
41361	Байгууллагад төлөх өглөг	53086034.42	809058823.87
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	4307040.61	9829795.25
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	3428650.00	3428650.00
414	Урьдчилж орсон орлого	325077.00	6173291.46
41440	Бусад урьдчилж орсон орлого	325077.00	6173291.46
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3523370319.52	10219784300.64
422	Урт хугацаат зээл	3523370319.52	10219784300.64
4221	Төгрөг	3522742919.52	10219647991.55
42217	Санхүүгийн бусад байгууллага	3522742919.52	10219647991.55
4222	Гадаад валют	627400.00	136309.09
42228	Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/	627400.00	136309.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4377547072.10	2842550608.40
51	Засгийн газрын хувь оролцоо	4377547072.10	2842550608.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3986864869.67	4061049869.67
51101	Өмч: - төрийн	3986864869.67	4061049869.67
512	Хуримтлагдсан үр дүн	94320571.23	-1599676689.23
51210	Өмнөх үеийн үр дүн	94320571.23	94320571.23
51220	Тайлант үеийн үр дүн		-1693997260.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	296361631.20	381177427.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7962064193.65	13890825469.62

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4260401303.57	4362239886.68
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4183748020.72	4085565855.93
110	Орлогын албан татвар	4183748020.72	4085565855.93

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1100	Хувь хүний орлогын албан татвар	4183748020.72	4085565855.93
110002	Үйл ажиллагааны орлого	4183748020.72	4085565855.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76653282.85	276674030.75
120	Нийтлэг татварын бус орлого	76653282.85	276674030.75
120002	Хүүгийн орлого		10571568.42
120003	Торгуулийн орлого		8814371.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	3399365.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3399365.06
120005	Түрээсийн орлого		6000000.00
120009	Бусад орлого	76653282.85	247888725.53
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4913781534.15	6056237147.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4728276414.58	5912148901.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4728276414.58	5912148901.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4394521516.34	873052054.77
210101	Үндсэн цалин	4394521516.34	873052054.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	132812054.39
210201	Тэтгэврийн даатгал		132812054.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	3160058228.81
210301	Гэрэл, цахилгаан		239045675.79
210302	Түлш, халаалт		2797140.00
210303	Цэвэр, бохир ус		84424020.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		2833791393.02
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	672456625.49
210401	Бичиг хэрэг		1584140.24
210402	Тээвэр, шатахуун		359891075.43
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		6837226.90

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		212295444.16
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		91848738.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	166874763.87
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		59927175.31
210604	Урсгал засвар		106947588.56
2107	Томилолт, зочны зардал	0.00	11005290.90
210702	Дотоод албан томилолт		11005290.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	333754898.24	245056433.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		166579438.16
210803	Даатгалын үйлчилгээ		1592493.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар		318800.00
210807	Газрын төлбөр		602440.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	333754898.24	
210813	Бусад зардал /ТӨҮГ/		75963262.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	650833449.07
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		650833449.07
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	185505119.57	144088245.99
2200	Дотоод эх үүсвэрээр	185505119.57	144088245.99
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	5410989.17	
225105	Бусад ашиг (алдагдал) /ТӨҮГ/	180094130.40	144088245.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-653380230.58</u>	<u>-1693997260.46</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-653380230.58</u>	<u>-1693997260.46</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4663990620.26	4671809182.04
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4415143404.51	4375108174.42
110	Орлогын албан татвар	4415143404.51	4375108174.42
1100	Хувь хүний орлогын албан татвар	4415143404.51	4375108174.42
110002	Үйл ажиллагааны орлого	4415143404.51	4375108174.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	248847215.75	296701007.62
120	Нийтлэг татварын бус орлого	248847215.75	296701007.62
120002	Хүүгийн орлого		10571568.42
120003	Торгуулийн орлого		9695808.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	3739301.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3739301.56
120005	Түрээсийн орлого		6600000.00
120009	Бусад орлого	248847215.75	266094328.74
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4865839250.78	5009277076.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4865839250.78	5009277076.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4865839250.78	5009277076.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	912820559.00	694629376.50
210101	Үндсэн цалин	912820559.00	694629376.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307170841.59	242334828.78
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	307170841.59	242334828.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1025638192.39	2503495096.08
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	1025638192.39	2503495096.08
2104	Хангамж, бараа материалын зардал	955293944.00	956825217.57
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	419639773.00	98386272.72
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	535654171.00	858438944.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1664915713.80	611992557.36
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	319992089.82	425188667.61
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	1344923623.98	186803889.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-201848630.52	-337467894.25
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	115127200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	115127200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	115127200.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		115127200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-115127200.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-47169061.05	358596.23
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		358596.23
250005	Төлсөн ногдол ашиг	-47169061.05	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-47169061.05	358596.23

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-249017691.57	-452236498.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	839229525.27	590211833.70
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	590211833.70	137975335.68

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,560,913,641.37	296,361,631.20	94,320,571.23	2,425,951,228.30	4,377,547,072.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,560,913,641.37	296,361,631.20	94,320,571.23	2,425,951,228.30	4,377,547,072.10
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,560,913,641.37	296,361,631.20	94,320,571.23	2,425,951,228.30	4,377,547,072.10
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,560,913,641.37	296,361,631.20	94,320,571.23	2,425,951,228.30	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,560,913,641.37	296,361,631.20	94,320,571.23	2,425,951,228.30	4,377,547,072.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	84,815,796.76	0.00		84,815,796.76
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	74,185,000.00	74,185,000.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,693,997,260.46		-1,693,997,260.46
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,560,913,641.37	381,177,427.96	1,599,676,689.23	2,500,136,228.30	2,842,550,608.40

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3749645300.00	4580026489.21	4800210156.00	6056237147.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3749645300.00	4580026489.21	4800210156.00	6056237147.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3749645300.00	4580026489.21	4800210156.00	6056237147.14
2101	Цалин хөлс болон	1074004000.00	924024200.00	879483185.00	873052054.77

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	нэмэгдэл урамшил				
210101	Үндсэн цалин	1074004000.00	924024200.00	879483185.00	873052054.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161474700.00	146278500.00	134686470.00	132812054.39
210201	Тэтгэврийн даатгал	161474700.00	146278500.00	134686470.00	132812054.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1003977800.00	692978700.00	433463759.00	418115574.55
210301	Гэрэл, цахилгаан	284027100.00	227726500.00	270490192.00	239045675.79
210302	Түлш, халаалт	589435700.00	364287600.00	55957515.00	94645878.76
210303	Цэвэр, бохир ус	130515000.00	100964600.00	107016052.00	84424020.00
210304	Байрны түрээс				
2104	Хангамж, бараа материалын зардал	626523600.00	542342570.00	366063510.00	603478385.07
210401	Бичиг хэрэг	530000.00	117100.00	2030000.00	1584140.24
210402	Тээвэр, шатахуун	585883400.00	502265570.00	285996524.00	359891075.43
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2194800.00	2110300.00	6825600.00	6837226.90
210407	Бусад зардал	37915400.00	37849600.00	71211386.00	235165942.50
2105	Нормативт зардал	0.00	0.00	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	611926000.00	806039800.00	656001780.00	853664141.86
210601	Багаж, техник, хэрэгсэл			33386000.00	35955928.92
210602	Үндсэн хөрөнгийн элэгдэл	471030000.00	595884300.00	523300000.00	650833449.07
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	65896000.00	65857600.00	49995780.00	59927175.31
210604	Урсгал засвар	75000000.00	144297900.00	49320000.00	106947588.56
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00	7346000.00	11005290.90
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт			7346000.00	10439200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				566090.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	233107200.00	1429825519.21	2194480048.00	2987770130.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		53215300.00		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох				
210803	Даатгалын үйлчилгээ			1197300.00	1592493.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1197300.00	962400.00	200300.00	318800.00
210805	Үл хөдлөх хөрөнгийн татвар	3409500.00	4304400.00	3767300.00	7376757.85
210806	Дулааны өртөг		1184798000.00	1990616148.00	2833791393.02
210807	Газрын төлбөр	1520900.00	1040300.00	1547000.00	602440.00
210808					
210809	Үйл ажиллагааны бу бусад зардал	226979500.00	185505119.21	197152000.00	144088245.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38632000.00	38537200.00	128685404.00	176339515.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38632000.00	38537200.00	128685404.00	176339515.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх				

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
		4143771000.00	4260401303.57	0.00	0.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	0.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4143771000.00	4260401303.57	0.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4143771000.0	4183748020.7		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		76653282.9		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		839229525.3		590211833.70
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		590211833.7		137975335.68
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	0.00	0.00
610001	Төсвийн байгууллага				
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	183.00	183.00	130.00	130.00
620001	Удирдах ажилтан	3	3	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	53	53	57	57
		23	23	18	18
620004	Гэрээт ажилтан	104	104	52	52

3. Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Б.Одхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

“Булган мээж” ОНӨХХК 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/92 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

“Булган мээж” ОНӨХХК нь тайлант хугацаанд “Иргэд байгууллагын эрх ашгийг эрхэмлэн хүндэлж, эрүүл ахуйн шаардлагад хангасан цэвэр ус түгээн нийлүүлж, хэрэглэгчдийг найдвартай дулааны эрчим хүчээр ханган ажиллах” гэсэн зорилго дэвшүүлж үүний хүрээнд доорх зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

1. Хэрэглэгчдэд цэвэр ус түгээх үйлчилгээг тасралтгүй хүртээмжтэй явуулж, орчин үеийн дэвшилтэт технологиор тоноглон автоматжуулах
2. Чадварлаг хүний нөөц, байгальд ээлтэй дэвшилтэт техник технологиор дулааны эрчим хүчний үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх
3. Байгууллагын үйлчилгээний стандарт, бизнесийн дэг жаягийг баримтлан хэрэглэгчээ дээдэлсэн ил тод, нээлттэй үйлчилгээг
4. Эдийн засаг, санхүүгийн алдагдлыг бууруулах, зардал хэмнэх
5. Шинэ санаа бүтээлч хандлагатай, мэргэжлийн өндөр мэдлэгтэй, багаар ажиллах чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх
6. Байгууллагын бүх хэсгүүдэд хийх дотоод хяналтыг сайжруулж зөрчил дутагдалгүй хамт олон болох гэсэн 6 зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй, байгууллагын НБББББ-ийг 2017 онд боловсруулж одоог хүртэл мөрдөн ажиллаж байна. Цаашид хуулийн журмын шинэчлэлтэй холбогдуулан шинэчлэн боловсруулах шаардлага үүсэж байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

“Булган мээж” ОНӨХХК санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэн боловсруулжээ.

ХАК нь 2020 онд “Булган мээж” ОНӨХХК 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд баталгаажуулах аудит хийж, нийт 13000.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 334.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3598.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 9067.5 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн хариуг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр биелэлтийг хүргүүлэн ажиллажээ.

ХАК нь 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил илрээгүй мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж дуусгавар болсон тайланд дурдсан байна.

Мөн ХАК нь эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-д тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт 2850921.4 мянган төгрөгийн зардлаас 2 хувиар буюу 57018.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон төлөвлөж, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт 6065237.1 мянган төгрөгийн зардлаас 2 хувиар буюу 121304.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон авч үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5928761.3 мянган төгрөгөөр буюу 42.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	590211.8	137975.3	-452236.5
Авлага	156284.0	208254.6	51970.6
Урьдчилгаа			
Бараа материал	378220.6	7075808.3	6697587.7
Үндсэн хөрөнгө	6837347.7	6468787.2	-368560,5
Нийт хөрөнгө	7962064.2	13890825.5	5928761.3
Өр төлбөр	3584517.1	11048274.8	7463757.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4377547.0	2842550.6	1534996.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7962064.2	13890825.5	5928761.3

Мөнгөн хөрөнгө дансанд 137975.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

Авлага дансны эхний 156284.0 мянган төгрөгийг үлдэгдлийг 51970.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж оны эцэст 208254.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 7075808.3 мянган төгрөг болж өмнөх оноос 6697587.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тухайн жилд аймгийн цэвэрлэх байгууламжийн 6696905.1 мянган төгрөгийн бараа материал орлогод авч нэмэгдүүлснээр тайлагнасантай холбон үзэж байна.

Тухайн жилд бусад байгууллага иргэдээс хандив тусламж аваагүй болно.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 6468787.2 мянган төгрөг болж 368560.5 мянган төгрөгөөр хасагдсан нь жилийн эцэст цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгө акталж хасагдсантай холбон үзэж байна.

Тухайн онд элэгдлээ бүрэн нөхсөн 84563.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж хуримтлагдсан үр дүнг 82582.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнажээ.

Өр төлбөр дансны үлдэгдлийг 7463757.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь худалдан авч байгаа дулааны өртгийн үнийн зөрүүгээр, аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн цэвэрлэх байгууламжийн хөрөнгийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэнтэй холбогдон гарсан үзүүлэлт байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдлийг 74185.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь зуслангийн газрыг үнэлэн үндсэн хөрөнгийн дансанд орлогоор бүртгэн авч тайлагнажээ.

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 4362239.9 мянган төгрөгийн орлого байгаа нь өмнөх оноос 101838.6 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь тухайн жилд аймгийн цэвэрлэх байгууламжийн 6696905.1 мянган төгрөгийн бараа материал орлогод авч нэмэгдүүлсэн үзүүлэлтийн өөрчлөлт байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 1142455.6 мянган төгрөгөөр буюу 23.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, эмийн зардал нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хуримтлагдсан үр дүн өмнөх оны хуримтлагдсан үр 1040617.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт худалдан авч байгаа дулааны үнэ нэмэгдсэн, нэмэлт уурын зуух ажиллуулсантай холбон үзэж байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

“Булган мээж” ОНӨХХК нь 2020 онд өөрийн үйл ажиллагааны орлогыг 4200399.8 мянган төгрөгөөр төлөвлөж ТУЗ-д хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд “Булган мээж” ОНӨХХК нь үйл ажиллагаандаа зарцуулахаар өөрийн үйл ажиллагааны орлогыг 4085565.8, бусад үйл ажиллагааны орлогоор 276674.0 мянган төгрөгөөр тус тус орлого бүрдүүлж гүйцэтгэлээр 5009277.1 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст харилцах дансанд 137975.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Улсын/орон нутгийн/төсөвт төвлөрүүлэх орлого

Төвлөрүүлэх орлого төлөвлөдөггүй болно.

3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлээгүй тул зөвлөмж хүрүүлж ажиллалаа.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 13000.0 мянган төгрөгийн зөрчлөөс 334.0 мянган төгрөгийн төлбөрийн 1 актыг барагдуулж, 3598.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 9067.5 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 7 зөвлөмжийг тус тус биелүүлсэн байна.

Хүснэгт 3: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мян/төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	334.0	1	334.0			
Албан шаардлага	1	3598.5	1	3598.5			
Зөвлөмж	7	9067.5	7	9067.5			
Нийт дүн	9	13000.0	9	13000.0			

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 118599.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1512.4 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 93801.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар 23286.2 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгч ажиллалаа.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 9000.0 мянган төгрөгийн алдаатай бичилтийг залруулж ажиллалаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 95313.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1512.4 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоон, 93801.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Тус байгууллагын шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад даргын цохолтоос илүү тооцож 238770 төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. “Булган мээж” ОНӨХХК-ий томилолтын зарцуулалтыг түүвэрлэн шалгахад томилолтын хуудасны тамга тэмдэг, буудлын баримттай зөрүүтэй анхан шатны баримтаар 333000 төгрөгийн томилолтын зардлыг зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Тус байгууллагын цалингийн нэмэгдлийг түүвэрлэн шалгахад тогтоол, шийдвэргүйгээр 940749 төгрөгийг илүү олгосон зөрчил илэрсэн нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 20.1.7 дахь “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4. Тус байгууллага нь бараа материалын тодруулга тайланд 10 машины грашийг 79801385 төгрөгөөр дуусаагүй барилгын дансанд бүртгэн тайлагнасан боловч ажил хүлээлцэх комисс хүлээж аваагүй, ажлыг хэсэг байгуулж ажиллаагүй байхад тус гаршийн барилыг ашиглаж байгаа зөрчил илэрсэн нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1-д “ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах”, 20 дугаар зүйлийн 20.7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах”, НБББББ-ийн Үндсэн хөрөнгө хүлээн зөвшөөрөлт хэсэгт “Үндсэн хөрөнгө нь компанийн ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн засгийн өгөөж олж авах магадлалтай бол, компанийн удирдлагаас хөрөнгийн өртгийг найдвартай үнэлэх боломжтой үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг үндсэн хөрөнгийн нягтлан бодогч гүйцэтгэнэ”, Үндсэн хөрөнгийн элэгдэл хэсэгт “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйл заалтын дагуу Нэг жилээс дээш хугацаанд ашиглах хөрөнгөнд элэгдэл хорогдлын шимтгэл тооцно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Тус байгууллага нь 2018 онд бараа материалын тодруулга тайланд 2 машины зогсоолын грашийг 14000000 төгрөгөөр худалдан борлуулна гэж бүртгэж тайлагнасан боловч одоог хүртэл худалдан борлуулалт хийх ажлыг зохион байгуулж ажиллаагүй нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1-д “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах”, 20 дугаар зүйлийн 20.7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар эмийн орлого зардлыг гүйцэтгэлтэй түүвэрлэн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тухайн байгууллагын нүүрсний орлого зарлагыг давхар зарцуулалт хийж тайлагнасан асуудал анхаарал татахуйц байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шатахуун түгээх НИК ХХК-тай тооцоо нийлж ажиллаагүй, даргын цохолтгүй шийдвэргүйгээр Дэл-агт ХХК-нд 1600 л буюу 3232.0 мянган төгрөгийн шатахууныг олгосон, анхан шатны баримт дутуу зөрчил илэрлээ.

1.2 Эрсдэл: Төсөвт зарцуулах хяналт сулрах

1.3 Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулж НББ-ийн тухай хуулийн 13.6, 13.7 дахь заалтыг мөрдөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хойшид анхаарч ажиллана.

2. Зардал данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Нүүрсний зарцуулалтын зарлагыг 189.8 тн буюу 5504.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

2.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

2.3 Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 13.7 дахь заалтыг мөрдөж ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч байна. Манай байгууллагын онцлогоос хамаарч, дотоод гүйлгээг эд хариуцагч нар дээр ингэж хийж байгаа юм.

3. Зардал данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Төлөвлөсөн зардлын гүйцэтгэлийг зардлын тайлангаас үзэхэд нийт 1318090745 төгрөгөөр илүү зардлыг зарцуулсан байна. Төлөвлөсөн зардлаас хэтэрсэн зардлыг дурдвал: /Тээврийн зардлыг 73894.5, засвар үйлчилгээний зардлыг 57627.6, албан томилолтын зардлыг 3093.2, элэгдлийн зардлыг 127533.4, шууд материалын

зардлыг 47654.1, хангамжийн материалыг 2569.9, шатахууны зардлыг 39333.9, хөдөлмөр хамгааллын зардлыг 9931.4, дулааны станц 846175.2, АТБӨЯХАТ-ын даатгалын зардлыг 395.2, үл хөдлөх хөрөнгийн татварыг 3609.4, АТӨЯХ-ийн татварыг 118.5, зар сурталчилгааны зардлыг 67.1/

- 3.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр төлбөр үүсэх
 - 3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3, 16.5.5 дахь заалтыг мөрдөж төсвийг оновчтой төлөвлөн батлуулж өр авлагыг багасгаж ажиллах.
 - 3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хойшид анхаарч ажиллана
 - 4. Хууль журамтай холбоотой асуудал
 - 4.1 Илрүүлэлт: Шилэн дансанд төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.
 - 4.2 Эрсдэл: Хууль журам зөрчигдөх
 - 4.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар заалтыг мөрдөж цаг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах.
 - 4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хойшид анхаарч ажиллана.
 - 5. Зардал данстай холбоотой
 - 5.1 Илрүүлэлт: Буцалтгүй тусламж, урамшууллын зардлыг 50000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 64550.0 мянган төгрөгийг зарцуулж 14550.0 мянган төгрөгийг илүү зарцуулалт хийгджээ.
 - 5.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага нэмэгдэх
 - 5.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг мөрдөж өр авлагыг багасгаж ажиллах
 - 5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хойшид анхаарч ажиллана.
- Дээрх 5 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Булган мээж” ОНӨХХК	Аудитын код:
2020			САГ-2021/3/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймаг дахь Төрийн аудитын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахуун зарцуулахдаа даргын цохолтоос илүү шатахуун зарцуулсан тооцоог 238770 төгрөгөөр илүү дутуу тооцоолж зарцуулсан байна.	238.7	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн

“Булган мээж” ОНӨХХК-ний 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Томилолтын тамга тэмдэг, буудлын баримт зөрүүтэй анхан шатны баримтаар 333000 төгрөг олгосон.	333.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
3	Тогтоол, шийдвэргүйгээр цалингийн нэмэгдлийг 940749 төгрөгөөр тооцож олгосон.	940.7	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
4	Машины гаршийн зогсоолыг 2018 оноос БМ-ын тайланд худалдан борлуулах дансанд бүртгэн авснаас хойш одоог хүртэл худалдан борлуулах ажил зохион байгуулж ажиллаагүй борлуулалтыг хийгээгүй байна.	14000.0	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
5	10 машины грашийн синдевчин барилгыг дуусаагүй барилгаар БМ-ын тайланд бүртгэж тайлагнасан боловч улсын комисс хүлээж аваагүй байхад ашиглаж байна./79801385/	79801.3	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
6	Төлөвлөсөн зардлын гүйцэтгэлийг зардлын тайлангаас үзэхэд илүү зардлыг зарцуулсан байна.	0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
7	Шилэн дансанд төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.	0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
8	Буцалтгүй тусламж, урамшууллын зардлыг 50000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 64550.0 мянган төгрөгийг зарцуулж 14550.0 мянган төгрөгийг илүү зарцуулалт хийгджээ.	14550.0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
9	Шатахуун түгээх НИК ХХК-тай тооцоо нийлж ажиллаагүй, даргын цохолтгүй шийдвэргүйгээр Дэл-агт ХХК-нд 1600 л буюу 3232.0 мянган төгрөгийн шатахууныг олгосон, анхан шатны баримт дутуу зөрчил илэрлээ.	3232.0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
10	Нүүрсний зарцуулалтын зарлагыг 189.8 тн буюу 5504.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	5504.2	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Б.Одхүү, А.Даваасүрэн
ДҮН		118599.9			

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Д.АНХБАЯР**
МЕНЕЖЕР **Ж.ЭНХЦООДОЛ**

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР **П.МӨНХТУЯА**